

ХҮЙТЭН ДАЙНЫ ҮЕИЙН ЗӨВЛӨЛТ ХЯТАДЫН СӨРГӨЛДӨӨН БА МОНГОЛ УЛС

Д.Уламбаяр*

Abstracts: *The Soviet-Sino split was the breaking of political relations between the CPC, PRC and the CPSU, USSR, caused by doctrinal divergences that arose from their different interpretations, ways of socialism built, and practical applications of Marxism-Leninism, as influenced by their respective geopolitics during the Cold War. Sino-Soviet debates about the interpretation of Orthodox Marxism became specific disputes about the Soviet Union's policies of national de-Stalinization, cult of personality, and international peaceful co-existence with the Western world. Against that political background, the international relations of the PRC featured official belligerence towards the West, and an initial, public rejection of the Soviet policy of peaceful coexistence between the Eastern block and the Western block, the Sino-Soviet was a question of who would lead the revolution for world communism, cultural revolution, border war, nuclear China. Soviet and Taiwan first contact, its outcomes, key issues of Mongolia-Sino relations, Lin Biao incident, Resolution of the Mongolian People's Revolutionary Party Central Committee Politburo on Joining the Warsaw Pact, 1963, top secret resolution of the Central Committee Politburo of the MPRP 1965, «three contrary barriers», its nature, the New Political Thinking: Collective Efforts and Normalization of Relations between Soviet-China-Mongolia, etc.,*

Keywords: *split, political relations, geopolitics, socialism, cold war, world communism, cultural revolution, border war, nuclear, secret resolution, secret resolution, new political thinking: collective efforts and normalization of relations.*

1960-аад оны эхнээс Хятадын коммунист нам (ХКН) социализм байгуулах зүй тогтол, арга зам, олон улсын ажилчны болон коммунист хөдөлгөөн, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний талаар ЗХУКН, социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас зарчмын ялгаатай байр суурь баримтлах болсон юм. Энэ бодлого, байр суурь Зөвлөлт-Хятадын харилцаанд ноцтой саад болж эхэлсэн байна.

1961 оны 10 дугаар сард хуралдсан ЗХУКН-ын XXII хурал ойрын 25 жилийн хугацаанд ЗСБНХУ-д коммунизмын материал, техникийн баазыг байгуулж дуусгах, коммунист нийгмийн харилцааг боловсронгуй болгох, коммунист бие хүнийг төлөвшүүлэх стратегийн зорилгын хүрээнд чадлынхаа хирээр хийж, хэрэгцээнийхээ хирээр хүртэх, оюуны болон биеийн хөдөлмөр, хот ба хөдөө, ажилчин ба тариачин ангийн хоорондын ялгааг арилгах, сэхээтний давхаргыг хөгжүүлэх, коммунист ёсоор аж төрөх зорилтыг дэвшүүлсэн ЗХУКН-ын III Программыг баталсан юм. Их хурлаар хэлэлцэгдсэн нэг том асуудал нь 1956 оны 2

* Д.Уламбаяр. ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал

дугаар сард хуралдсан ЗХУКН-ын ХХ их хурлаас Сталиныг тахин шүтэх, түүний хор уршгийг хэлэлцсэн асуудлыг дахин хурцаар хөндөн тавьсан юм. Энэ асуудал ХКН-ын эгдүүцлийг хөдөлгөсөн байна. Учир нь Хятадад Мао Цзедуныг тахин шүтэх үзэл газар авч байсан юм. 1966 онд Хятадад өрнөсөн “соёлын хувьсгал” ч Зөвлөлт-Хятадын харилцаанд ноцтой сөрөг нөлөө үзүүлэв.

1969 оны 3 дугаар сард Приморийн хязгаарын Пожарскийн дүүрэгт багтах Уссури мөрний Даманы аралд (0,74 км²) (Чжэньбао-дао буюу “эрдэнэс” гэсэн үг ажээ Д.У) болсон зэвсэгт мөргөлдөөн Зөвлөлт-Хятадын харилцаа туйлдаа хүртэл хурцадсныг харуулав. 1860 оны Бээжингийн гэрээгээр Уссури мөрний цаад эрэг дагуу Хятадын хил оршдог жижиг арал нь ЗХУ-ын нутаг дэвсгэрт тооцогддог байжээ. 1919 оны Парисын бага хурлаас гаргасан зарчмын дагуу усан замын тээвэр ашигладаг мөрний дундах хуурай газрыг усан замын бүсэд тооцохгүй байх ёстой тул хятадууд Бээжингийн гэрээг дангаараа өөрчлөхөөр шийдвэрлэсэн байв. Энэ арлын байгалийн гол баялаг нь үнэ цэнэтэй үлэмж арвин усны хадлан (заливной луг) байжээ. 1969 оны 3 дугаар сарын 2-15-ны хооронд болсон мөргөлдөөний төгсгөл үед Зөвлөлтийн тал дөнгөж зэвсэглэлд орж байсан шинэ зэвсэг болох «БМ 21 Град» бөөнөөр галлах пуужингийн тийрэлтэт систем ашигласан байна. Тухайн үеийн зөвлөлтийн Правда болон Известия сонины мэдээллээр бол тэр үед Даманы арал дээр байсан хятадын 700 гаруй цэргийг газартай нь тэгшилсэн ажээ. Хоёр долоо хоног үргэлжилсэн энэхүү мөргөлдөөнд Зөвлөлтийн 58 цэрэг амь үргэж, 100 гаруй цэрэг хүнд шархадсан байна. Энэ тулаанд Зөвлөлтийн 5 офицер байлдагч ЗХУ-ын баатар цолоор нэхэн шагнагджээ.² 2010 онд *Le Figaro* сонин энэ мөргөлдөөний үед ЗХУ цөмийн цохилт өгөхөд бэлэн байсан гэдгийг дэлгэсэн билээ. Хамгийн ноцтой нь БНХАУ 1964 оны 10 дугаар сарын 16-нд Шиньжан мужийн Лоб нуурын цөлд анхны цөмийн бөмбөгийн туршилт хийсэн явдал байв. 1950-иад онд ЗХУ цөмийн зэвсгийн нууцаас БНХАУ-тай хуваалцах албан ёсны гэрээ хэлэлцээ явагдаж байсан бөгөөд Хятадын цөөнгүй цөмийн физикчид Москвагийн ойролцоо Дубна дахь Цөмийн судалгааны институтэд бэлтгэгдэж төгссөн байв.

Хууль эрхзүйн талаасаа хятадуудын зөв байсан ажээ. Хил голын голдрилоор байсан. Арал эхлээд Зөвлөлтийн талд байжээ. Тэр үед голын урсгал өөрчлөгдөөд, арал хилийн нөгөө талд орсон ажээ. ЗХУ 1991 оны 5 дугаар сарын 19-нд Даманы арлыг БНХАУ-д албан ёсоор шилжүүлэн өгсөн байна. Зөвлөлт-Хятадын хилийн энэхүү зэвсэгт мөргөлдөөн Монгол-Хятадын харилцаанд шууд нөлөөлж, хурцадмал байдал 1970-аад оны туршид үргэлжилсэн юм.

БНХАУ 1964 оны 10 дугаар сарын 16-нд Шиньжан-Уйгурын цөлд Лоб нуурын орчимд анхны атомын бөмбөгийн туршилт хийж, 1965 оны 5 дугаар сарын 14-нд хоёр дахь туршилтаа хийжээ. Аль аль нь уран 235 байсан бөгөөд иймэрхүү нэг бөмбөг бүтээхэд 350 сая ам. доллар болж байжээ.

Хятад 1967 оны 6 дугаар сарын 17-нд устөрөгчийн бөмбөгийн анхны

² Мусалов Андрей. Даманский и Жаланашколь. Советско-китайский вооруженный конфликт 1969 года. - М.: Экспринт, 2005. - ISBN 5-94038-072-7. с. 336-369

туршилтаа амжилттай хийж, 1968 оны 12 дугаар сарын 27-нд хоёр дахь удаагаа, 1969 оны 9 дүгээр сарын 29-нд гурав дахь удаагийн туршилтыг хийжээ.³ “Атомын бөмбөгөөс устөрөгчийн зэвсэг турших хүртэл АНУ 6 жил 4 сар, Англи 4 жил 7 сар болсон байна. Тэгвэл Хятад анхны атомын бөмбөгөөс устөрөгчийн бөмбөгийн туршилт хүртэл 2 жил 8 сарын хугацаа зарцуулав гэж 1969 оны 9 дүгээр сарын 29-нд Синьхуа агентлаг мэдэгдсэн байна. Мэргжилтнүүдийн тооцоолсноор эдгээр туршилтыг хийхэд БНХАУ нийтдээ 6 тэрбум ам. доллар буюу 15 тэрбум юань зарлагджээ. Гэтэл тухайн үеийн Хятадын гадаад худалдааны эргэлт дөнгөж 4 тэрбум орчим ам. доллар байжээ. Ураны нөөц Хятадад хомс боловч гол нөөц нь Шиньжанд байршилтай учир Өрөмч хотод ураны хүдэр баяжуулах үйлдвэр, харин түүнтэй хиллэдэг Ганьсу мужийн Ланьчжоу хотын орчимд уран баяжуулах үйлдвэр нь байрладаг байжээ.

Хятад 1970 оны 1 дүгээр сарын 30-нд анхныхаа хиймэл дагуул DF-4-ийг, 4 дүгээр сарын 24-нд хоёр дахь удаагаа амжилттай хөөргөжээ. “Dong Fang Hong” буюу “Дорно зүг улайрав” буюу “Мао-1” нэртэй 173 кг жинтэй хиймэл дагуул дэлхийг 114 минутад нэг бүтэн тойрч, “Дорно зүг улайрав” хэмээх дууны хөгжмийг дамжуулсан байна.⁴ 1971 оны 10 дугаар сард DF-5 тив хоорондын баллистик (12 мянган км) пуужингийн анхны туршилтыг хийж, 1980 онд зэвсэглэлд авчээ. Эдгээр нь Мао Цзедуны үзэл санааны их ялалт, хятадын сансрын болон пуужингийн техникийн хөгжлийн сайн гарааны бэлэг тэмдэг гэж Синьхуа агентлаг тухайн үедээ дүгнэж байжээ.

Цөмийн зэвсэг, алсын тусгалтай баллистик пуужин бүхий олон зуун сая хүн амтай гүрэнтэй хуурай замаар олон зуун км газар нутгаар хаяа хатган хиллэх болсон нь ЗХУ-ын хувьд Өрнөдөөс гадна Дорнодоос цоо шинэ ноцтой аюул буй болсныг харуулсан юм. Энэ үед ЗХУ Тайваньтай харилцаагаа сэргээх хувилбарыг ч авч үзэж эхэлжээ. Энэ нь Хятадыг АНУ-тай, Зөвлөлтийг Энэтхэг улстай, ЗХУ-ыг АНУ-тай харилцаагаа сайжруулан хөгжүүлэх шаардлагатайг харуулсан юм.

1960-аад оны сүүлчийн улирлаас Зөвлөлт-Хятадын харилцаа эрс хурцдах болсон үед ЗХУ Тайваньтай албан бус шугамаар харилцаж эхэлжээ. Үүнд: Москва дахь “Western media outlets”-ийн төлөөлөгч “New York Times”, Лондонгийн “The Evening News” сонины сэтгүүлч КГБ-ын нууц туршуул, Виктор Луи (Victor Louis 1928-1992) чухал үүрэг гүйцэтгэжээ. Тэрбээр “Wang Ping” нэрээр Японы нийслэл Токиод Тайванийн ТТГ-ын шугамаар холбоо тогтоож 1968 оны 10 дугаар сард Тайбэйд зочилж, Батлан хамгаалахын сайд Зян Зинго (Chiang Ching-kuo Чан Кайшигийн төрсөн том хүү) лугаа уулзаж, 1969 оны 5 дугаар сар, 1970 оны 3 дугаар сард Австрийн нийслэл Вена хотноо Тайванийн дипломатуудтай нууц уулзалтуудыг зохион байгуулж байжээ. Уулзалтын агуулгад Маогийн дэглэмийг түлхэн унагаах, хамтын ажиллагааны нууц гэрээ байгуулах, шинэ Хятадын төрийн системд Коммунист намын нэрийг хэрэглэх албагүй, Гоминьдан, Коммунист намын

³ Peking Review. №44 1968

⁴ Eastern Horizon. Vol. IX, №2 1970

нэгдсэн Засгийн газар нь шилжилтийн шинж чанартай байх, хоёр талын харилцааг “Элчин сайдын зиндаа”-нд дээшлүүлэх, Москва, Тайбэй хоёрт харилцан хэвлэл мэдээллийн газар байгуулах зэрэг өргөн хүрээтэй асуудлууд тусгагдаж байжээ.⁵

1990 оны намар Хятадын БНУ-ын Гадаад хэргийн дэд сайд Чан Циао-ен (Chang Hsiao-yen) 1970-аад оны эхээр Вашингтонд Зөвлөлтийн дипломатуудтай холбоо тогтоож байсан талаар хэвлэлийн бага хурлын үеэр мэдэгдсэн юм. 1992 оны 4 дүгээр сарын 11-нд Хятадын БНУ-ын Гадаад хэргийн сайд Чиен Фу (Chien Fu) Оросын *Известия* сонинд ярилцлага өгөхдөө: АНУ-ын нийслэлд Зөвлөлтийн элчин сайд А.Добрынинтэй “close ties” тогтоосон тухай тэмдэглэсэн байна.⁶

1995 оны 5 дугаар сард Taipei *China News*-ийн сэтгүүлч Lien-ho Pao Хятадын БНУ-ын Засгийн газрын Мэдээллийн агентлагын захирал агсан Jimmy Wei-гийн мэдээллийг үндэслэн 1960 оны сүүлч, 1970-аад оны эхээр КГБ-ын агент Виктор Луи лугаа холбоо тогтоож байсан талаар бичсэн юм. Ман Виктор Луи Батлан хамгаалахын сайд Зян Зингогийн орос эхнэр Faina Chiang Fang-Liang-тай 3-4 удаа захидлаар харилцаж байжээ.

Түүнчлэн 1968 оны 10 дугаар сард Хятадын БНУ-ын Боловсролын яамны сайд асан Ku Shu-hsu Москвад нууц айлчлал хийж байсан, 1970-аад оны эхээд Пескадорын арал дээр ЗХУ-ын тэнгисийн цэргийн бааз байгуулах хүсэлт Чан Кай-шид ирж байсан, 1975 оны 5 дугаар сард Тайванийн хоолойгоор Зөвлөлтийн Номхон далайн флотын байлдааны хөлөг өнгөрөхөд Тайбэй зөвшөөрөл өгч байсан, 1978 онд Хятадын БНУ ЗХУ-тай дипломат харилцаа тогтоох боломжтой гэсэн Москвад тархсан цуурхал, 1978 оны 11 дүгээр сард Зөвлөлтийн худалдааны хөлөг онгоц Тайванийн Макунг (Makung) боомтод ирсэн тухай мэдээ, 1982 оны 8 дугаар сард Москвад зохиогдсон Олон улсын эрүүл мэндийн байгууллагын их хуралд Тайванийн 18 зүрхний эмч нар төлөөлөгчөөр оролцож байгаа тухай, 1987 онд Москва хотноо зохиогдсон эмэгтэйчүүдийн сагсан бөмбөгийн олон улсын тэмцээнд Гоминьдан намын ТХ-ны Байнгын хорооны гишүүн, Тайбэй хотын Захиргааны дарга Chang Chien-rang тэргүүтэй төлөөлөгчид оролцож байсан зэрэг баримтууд байгааг Петер Иванов өгүүлэлдээ тэмдэглэсэн байна.⁷

Харин Зөвлөлт-Америкийн харилцаа огцом сайжирмагц тэрхүү албан бус харилцаагаа зогсоосон байна. Дээрхийн гэгээн XIV Далайн лам 1979 оны 6 дугаар сарын 15 буюу билгийн тооллын XVI жарны шороон хонин жилийн зуны эхэн сарын 20-ны билигт сайн өдөр Монгол Улсад Азийн Буддистууд Энхтайвны төлөө олон улсын V бага хурлын хүндэт зочноор уригдан анх заларчээ. Түүнийг Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба, Азийн буддистууд Энхтайвны төлөө бага хурлын Ерөнхийлөгч номч мэргэн гавж С.

⁵ Shin Kawashima. «The Little Dragon and the Bear: Soviet-Taiwanese Relations». Woodrow Wilson Center, Cold War International History Project, History and Public Policy Program. 17 December 2002

⁶ Peter M.Ivanov. «Russian-Taiwanese Relations: Current State, Problems, and Prospects of Development»- *Contemporary Asian Studies Series*. Number 2-1996 (133) School of Law University of Maryland, pp.2-3

⁷ *Ibid.* p.4-6

Гомбожав⁸ урьжээ.

Тэрбээр Монголд залрах замдаа ЗХУ-аас виз авч ирсэн байх бөгөөд энэ үед ЗХУКН-ын Төв Хороо БНХАУ-тай тааламжгүй харилцаатай байсан Дээрхийн гэгээн XIV Далай ламтай холбоо тогтоох сонирхолтой байжээ. Хүйтэн дайны үед ЗХУКН-тай ойртох нь хүний эрх, шашны эрх чөлөө, ардчилалыг дээдлэгч Өрнө дахинд болгоомжлол төрүүлэх эрсдэлтэй байсан тул татгалзаж байжээ. Түүнийг Шерметьевийн нисэх буудалд Бүх Оросын үнэн алдартны шашны тэргүүн XIV Патриарх, Москвагийн Сүм дуганы тэргүүн I Пимен угтан авч байжээ. Тэрбээр Монголд айлчлах хугацаандаа Монголын Бурхан шашины төв Гандантэгчэнлин хийдэд сүсэгтэн олонд “Гандан лхавжаа”, “Есөн мөрт мигзэм”, “Дөрвөн мөрт мигзэм” айлдан сүсэгтэн олны хамтаар маань уншиж “Язгуурын гурван бурханы тарни”-ийн лүн хайрлаж, Азийн Буддистууд Энхтайвны төлөө олон улсын V бага хуралд айлтгал өргөж байжээ. 1969 онд Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба, номч мэргэн гавж С. Гомбожавын санаачлан үндэс суурийг нь тавьсан Азийн Буддистууд Энхтайвны төлөө бага хурал “Зэвсэг барин тэмцсэн дайсагнагч талууд цэцэг барин золгох болтугай” (May the Weapons of Torture they hold turn to Flowers) гэсэн эрхэм уриатай ажгуу.

1970-аад онд Алс Дорнодод явуулж байсан бодлогын гол чиглэл нь БНХАУ-ыг «хазаарлан барих» явдал болов. Тиймээс зөвлөлт, хятадын хилийн дагуу цэргийн хүч болон Номхон далайн флотоо бэхжүүлэхийн зэрэгцээ Хятадын өмнөд хэсэгт Зөвлөлтийг дэмжигч орнуудын (социалист Вьетнам, арчилсан Лаос, Кампучи) гинжин цуваа байгуулж бүслэлт буй болгохыг эрмэлзэж байв. Чухам тийм учраас Бээжин болон Хойд Солонгосын харилцаа улам бүр ойргон нягтарч байгаад ЗХУ сэтгэл түгшин ажиглаж байжээ. 1973 онд ЗХУ БНАСАУ-д зэвсэг нийлүүлэхээ зогсоож, БНХАУ анх удаагаа тус улсад зэвсэг нийлүүлэгч гол орон болсон байна.

Бодлогын өөр нэг чиглэл нь Хятадын эсрэг үзэл суртлын тэмцлийг бүх

⁸ **Самаагийн Гомбожав** (1902-1980) нь Сэцэн хан аймгийн Харцага чин вангийн хошууны нутагт 1902 онд мэндэлжээ. 1913 онд Их хүрээний буддын гүн ухаан судалдаг Идгаачойнзинлин дацанд ирж сууж буддын гүн ухааны шастир номонд ихэд суралцжээ. Хамбатан Идгаачойнзинлин дацанд чойрын гүн ухааны судар номуудыг Гадин засгийн хошууны анги Цэрэндорж, Түшээт хан аймгийн Далай гүний хошууны харьяат Их хүрээний Идгаачойнзинлин дацангийн шунлайв Раднаа нарын буддын гүн ухаанд ихэд гэгээрсэн эрдэмтэн мэргэдээр заалгаж буддын гүн ухааны таван ботийн номыг судлаад 1935 онд гавжийн дамжаа барьжээ (докторын зэрэг хамгаалжээ Д.У). Түүний багшлах, ном заах эрдэм энэ үеэс эхэлсэн байна. Гомбожав хамба 1935 онд гавж болсны дараагаар буддын гүн ухаанд нэвтэрсэн лам нар дугаа хамтран “Лам нарын сэтгүүл”-ийг гаргах тухай Засгийн газарт өргөдөл гаргаж, улмаар 1936 оны 4 дүгээр сарын 20-нд Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайдаас гаргасан 51-р тушаалаар “Лам нарын сэтгүүл”-ийн анхны дугаар хэвлэгдэн гарч байжээ. 1951-1960 онд Шинжлэх ухааны хүрээлэн, Улсын Төв номын сангийн Түвд номын фондын эрхлэгч, 1960 онд Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба ламаар өргөмжлөгдсөн байна. 1961 онд Гандантэгчэнлин хийдийн Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр хамба лам С.Гомбожавт “Номч мэргэн” (профессор Д.У) цол олгожээ. 1961 онд МУИС-д шинээр нээгдсэн түвд хэлний салбарт шашны гүн ухаан, түвд хэлний салбарт багшилж байв. 1970 онд Гандантэгчэнлин хийдийг түшиглэн Шашны дээд сургуулийг санаачлан үндэс суурийг тавьж, Монгол болон Зөвлөлт Буриадаас шавь-оюутнуудыг элсүүлэн сургаж шашны дээд боловсрол олгож эхэлжээ. Түүний 70 насны ойг тохиолдуулан төр засгаас “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”-ийн одонгоор шагнажээ. 1969 онд Азийн Буддистуудын Энхтайвны Бага хурлыг үндэслэн байгуулж, анхны Ерөнхийлөгчөөр ажиллаж байв. Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба ламаар 20 жил ажиллаж байгаад 1980 онд жанч халжээ.

салбарт идэвхжүүлж, **маоизмын** мөн чанарыг уудлан илчлэх явдал байсан юм. Коммунизмын өсөн нэмэгдэж буй нөлөөллийг тогтоон барихын тулд 1960 оны 1 дүгээр сарын 19-нд Вашингтон хотноо АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Христиан А. Хертер (Christian A. Herter), Японд суугаа АНУ-ын элчин сайд Дуглас МакКартур II (Douglas MacArthur II), АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын Зүүн Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн орлогч Грахам Персонз (J. Graham Parsons), Японы Ерөнхий сайд Нобусуке Киши (Nobusuke Kishi), Гадаад хэргийн сайд Айчиро Фузияма (Aichirō Fujiyama) нар “Япон, АНУ-ын хооронд Харилцан хамтын ажиллагаа, Аюулгүй байдлын Гэрээ” хэмээх цэргийн холбоотны хоёр дахь эрхзүйн үндсэн баримт бичигт гарын үсэг зурсан нь БНМАУ-ын удирдагчдийн санааг ихэд зовоожээ. Үүнээс үндэслэн 1963 оны 7 дугаар сарын 15-нд хуралдсан МАХН-ын ТХ-ны Улс Төрийн товчооны хуралдаанаас “Варшавын Гэрээнд нэгдэн орох тухай” 24 дүгээр тогтоол гаргаж байжээ. Үүнийг дор бүрэн эхээр нь орчуулан сийрүүлбэл дараах мэт.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн товчооны тогтоол. Варшавын гэрээнд нэгдэн орох тухай⁹ 1963 оны 7 дугаар сарын 15, №24

«Одоо цагт Америкаар тэргүүлсэн империалистүүд олон улсын нөхцөл байдлыг хурцатгаж, дайнд эрчимтэй бэлтгэж байгаа нь дэлхийн ард түмэн, социалист лагерийн орнуудын энхтайван, аюулгүй байдалд ноцтой заналхийллийг учруулж байна. Жишээлбэл тодорхой баримтыг дурдахад, Америкийн империалистүүд 1960 оны 1 дүгээр сарын 19-нд АНУ, Японы хооронд байгуулсан “аюулгүй байдлын гэрээ”-г ашиглан Японы нутаг дэвсгэр дээр цэргийн бааз байгуулж, Японы армид цөмийн зэвсэгт холбоотой тоног төхөөрөмж нийлүүлж буй нь БНМАУ-ын эрх чөлөө, бүрэн эрхт байдал, Монголын ард түмний социализм байгуулах үйл хэрэгт бодитой аюул заналхийлэл болж байна. Энэхүү аюултай нөхцөл байдалд марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчимд суурилсан социалист лагерийн орнуудын эв нэгдлийг хүчирхэгжүүлэн бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай болж байна. 1955 онд Европын социалист орнуудын хооронд байгуулсан Варшавын гэрээ бол нийт социалист орнуудын ард түмний энхтайван, аюулгүй байдал, энхтайван нөхцөлд социализм, коммунизмыг байгуулах, эрх чөлөө, бүрэн эрхт байдлын бодит баталгаа болж байна. Варшавын гэрээний орнуудын арми нь орчин үеийн зэвсэг техникээ шинэчлэх үндсэн дээр батлан хамгаалах хүчин чадавхиа бэхжүүлж, олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөний итгэлцлийг урагшлуулж байна. Дээр дурдсан бодит аюул заналхийллээс үүдэн тус улсын батлан хамгаалах чадавхийг бэхжүүлэх, юуны өмнө манай ардын армийг орчин үеийн зэвсэг, технологи, нийт бие бүрэлдэхүүн генерал, офицер, байлдагчдыг орчин үеийн цэргийн шинжлэх ухаанд сургах нь зүйтэй гэж үзэж МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчооноос шийдвэрлэх нь:

⁹ New Documents on Mongolia and Cold War. Translation and Introduction by Sergey Radchenko. Document №4 Relolution of the Mongolian People’s Revolutionary Party Central Committee Politburo on Joining the Warsaw Pact, 15 July 1963, МАХН-ын Төв Хорооны архив. Ф.4, Д.26, ХН. 306, Хуудас 40-41

1. Нийт социалист орнуудын ард түмний энхтайван, аюулгүй байдал, энхтайван нөхцөлд социализм, коммунизмыг байгуулах, эрх чөлөө, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын найдвартай үндсийг бүрэлдүүлэх үүднээс БНМАУ-ыг Варшавын гэрээнд нэгдэх орох нь зүйтэй гэж үзсүгэй.
2. Варшавын гэрээнд нэгдэн орох хүсэлт гаргах, энэ чиглэлээр Варшавын гэрээ, Бүгд Найрамдах Польш Ард Улсын Засгийн газартай ажиллахыг Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалд үүрэг болгосугай.

Улс Төрийн товчооны гишүүд:

Цагаанлхамын Дүгэрсүрэн

Нямын Жагварал

Дамдинжавын Майдар

Дэмчигийн Моломжамц

Жамсрангийн Самбуу

Юмжаагийн Цэдэнбал

Лувсанцэрэнгийн Цэнд

Улс Төрийн товчооны орлогч гишүүн:


Н.Лувсанравдан

МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Б.Лхамсүрэн»¹⁰ гэсэн байна. Гэвч үүнийг ЗХУКН дэмжээгүй бололтой байдаг юм.

Тиймээс дээрхийн дараа Зөвлөлт, Хятадын харилцааны хурцадмал байдалтай холбоотойгоор 1965 оны 12 дугаар сарын 1-нд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны хурал болж, “маш нууц” тодотголтой тогтоол батлаж, НТХ-ны Улс төрийн Товчооны гишүүн Ц.Дүгэрсүрэн, Н.Жагварал, С.Лувсан, Д.Майдар, Д.Моломжамц, Ж.Самбуу, Ю.Цэдэнбал, орлогч гишүүн Н.Лувсанравдан, Б.Лхамсүрэн нар гарын үсгээ зуржээ. Түүнд:

1. Дорнодод байдал хурцадаж олон улсын хооронд түгшүүрт байдал улам хүчтэй болж байгааг харгалзан тус улсын батлан хамгаалалтыг улам зузаатгах нь зүйтэй гэж үзсүгэй. Үүний тул ЗХУ-ын Зэвсэгт хүчнээс зохих ангийг гаргаж тус улсын нутагт байрлуулан өөрийн зардлаар барьж байх тухай хүсэлтийг ЗХУКН-ын Төв Хороо, Зөвлөлтийн Засгийн газарт тавих нь зүйтэй гэж үзсүгэй.


¹⁰ *Ibid.*



Тогтоолд гарын үсэг зурсан дарууд тухайн өдрөө МАХН-ын ТХ-ны Нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалаас ЗХУКН-ын ТХ-ны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Л.И.Брежнев, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга А.Н.Косыгин нарт маш нууц захидал илгээжээ. Түүнд:

“Дорнодод олон улсын байдал хурцдаж байгааг харгалзан улс орныхоо батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх арга хэмжээ авч байна.

- ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламжаар Монголын ардын армийг орчин үеийн зэвсэг техникээр хангаж, армийн бие бүрэлдэхүүнийг зөвлөлтийн мэргэжилтнүүд сурган бэлтгэж байна. Гэхдээ гэнэтийн халдан түрэмгийлэл үйлдвэл эдгээр арга хэмжээ нь хангалттай баталгаа болж чадахгүй.
- Эдгээрийг харгалзан БНМАУ-ын батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх зорилгын үүднээс ЗСБНХУ-ын Зэвсэгт хүчнээс цэрэг гаргаж, ЗХУ өөрийн зардлаар Монголд байршуулан, тэдгээр цэргийг орчин үеийн байлдааны хүчирхэг зэвсэг техникээр хангаж, ахуй соёл, аж ахуй болон бусад зайлшгүй объектуудаар хангалт хийхийг хүсч байна.
- Цэрэг байрлуулах газрын тухай болон бусад тодорхой асуудлыг жич хэлэлцэе.
- Манай хүсэлтийг ЗХУКН-ын Төв Хороо, Зөвлөлт Засгийн газар ойлгон хүлээн авч нааштай шийдвэр гаргана гэдэгт хатуу итгэж байна” гэжээ.



Дээрх хурал болон захидал илгээсэн нь Л.И.Брежнев тэргүүтэй ЗСБНХУ-ын нам, засгийн төлөөлөгчдийн БНМАУ-д хийх албан ёсны айлчлалаас сар хагасын өмнө бөгөөд айлчлан ирсэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ЗСБНХУ-ын Батлан хамгаалах яамны сайд ЗХУ-ын маршал Р.Я. Малиновский оролцсон нь анхаарал татаж байв.

1966 оны 1 дүгээр сарын 15-нд Улаанбаатар хотноо Монгол, Зөвлөлтийн удирдагч Ю.Цэдэнбал, Л.И.Брежнев нарын гарын үсэг зурсан «Найрамдал, хамтын ажиллагаа ба харилцан туслалцах тухай Гэрээн»-д:

- Социалист хамтын нөхөрлөлийн батлан хамгаалах хүч чадлыг хэлбэрэлтгүй бэхжүүлэх зорилттой уялдуулан хоёр этгээдийн батлан хамгаалах чадварыг хангахад харилцан туслалцах тухай;
- Найрсаг уламжлал ба НҮБ-ын Дүрмийг мөрдлөг болгон хоёр этгээдийн аюулгүй байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор цэргийнхнийг оролцуулан бүх талын зайлшгүй арга хэмжээг хамтран авах тухай;
- Улс түмний энхтайван, аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх, зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах, колоничлолыг устгах, Азийн улсуудын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд чиглэсэн бодлогыг СССР, БНМАУ хоёр тууштай явуулан, дэлхийн бөмбөрцөгийн энэ бүс нутагт империалист түрэмгийллийн аюулаас сэргийлж, тийм аюулыг арилгахын төлөө хамтран тэмцэнэ хэмээн тус тус заажээ.

Дурдсан заалтууд 1960-аад оны II хагаст Зөвлөлтийн цэрэг Монголд дахин орж ирж байрших эрхзүйн үндэс болсон байна. 1966 оны 1 дүгээр сард БНМАУ,

ЗСБНХАУ-ын хооронд “Найрамдал, хамтын ажиллагаа ба харилцан туслалцах” тухай гэрээний дараа байгуулсан хэд хэдэн эрхзүйн баримт бичиг гарсан байна. Юуны өмнө цэрэг оруулж байрлуулахыг бататгаж 1967 оны 3 дугаар 4-нд гарын үсэг зурсан “БНМАУ-ын нутаг дэвсгэрт Зөвлөлтийн цэргийг байрлуулах тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийг нэрлэх хэрэгтэй. Дурдсан хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 59 дүгээр тогтоол 1969 оны 8 дугаар 11-нд гарч, зөвлөлтийн цэргийн анги нэгтгэлүүдэд 410.073.42 га (Дөрвөн зуун арван мянга гаруй буюу бараг хагас сая гектар) газар олгожээ. Мөн 1969 оны «БНМАУ-ын иргэний хамгаалалтыг бэхжүүлэхэд тусламж үзүүлэх тухай Засгийн газар хоорондын нууц хэлэлцээр», 1971 оны «Цэргийн техникийн нэгдсэн засварын газар байгуулах тухай нууц солилцох бичиг», «БНМАУ-д тусгай объект байгуулахад буцалтгүй тусламж үзүүлэх тухай Засгийн газар хоорондын нууц хэлэлцээр», 1981 оны «БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ураны орд газрыг ашиглах тухай нууц хэлэлцээр» зэргийг дурдаж болно.¹¹

Хятадын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Дэн Сяопин 1979 оны 1 дүгээр сарын сүүлчээр АНУ-д албан ёсны айлчлал хийж ирээд удаагүй мөн оны 2 дугаар сарын 17-нд БНХАУ-ын цэргийн хүч Кампучийг “түрэмгийлсэн” БНСВУ-ыг хашраах үүднээс тус улсад халдан довтолсон нь олон улсын харилцаанд томоохон асуудал үүсгэв. Үүнтэй холбоотойгоор Өвөрбайгалийн цэргийн тойргоос зөвлөлтийн цэргийн тодорхой анги салбарууд Монголд нэмэлтээр дахин орж иржээ.

Хятад-Вьетнамын дайны үеэр Украин, Белорусаас нисэх хүчний хэд хэдэн хороодыг Монгол руу тагаж ирсэн ба Хятадын ар шилэн дээр (хойд хил дагуу) цэргийн сүрийг үзүүлэх замаар энхтайван, шударга ёсыг сэргээн тогтоох амаргүй үүргийг өөртөө хүлээсэн байдаг. ЗХУКН-ын ТХ-ноос гаргасан шийдвэрийн дагуу 1979 оны 3 дугаар сарын 12-26-нд хоёр 7 хоногийн турш хил орчмын цэргийн тойргууд, Монгол дахь ерөнхий цэргийн арми, Номхон далайн флотыг дайчлан тийнхүү сүрийг үзүүлэх цэргийн хээрийн ба далайн сургууль хийжээ. Нийт 20 гаруй дивизийг Хятадын хойд хилийн орчимд тоглолтод оролцуулсан ба чингэхдээ 200 мянган цэрэг, 2600 танк, 900 нисэх онгоцыг хөдөлгөж, далайд байлдааны 80 хөлөг онгоцыг гаргажээ. Үүнд: Монголын тал хээр, говьд явагдсан сургуулилт анхаарал татсан байна. Монголын армиас гадна зөвлөлтийн армийн 6 дивиз оролцсоноос гурав нь эргэж нутаг буцалгүй Монголд үлджээ. Монголын нутагт хоёр бригад, агаарын гурван дивиз орж ирээд эргээд гарсан байдаг. Сибириэс Монгол руу 2000 км маршилсан дайчилгааны хээрийн сургууль хамтдаа явагдаж төмөр зам, агаарын зам, хуурай замын бүх гарцыг ашиглажээ. Хятадын хилийн районуудад контрудар өгөх, контратак хийх цэргийн тактикийг тэр үед боловсруулсан цэргийн урлагийн гайхамшигт тоглолт болсон хэмээн дүгнэж байжээ.

1970-аад оны эхээр Монгол-Хятад, Зөвлөлт-Хятадын харилцаанд учир

¹¹ Д.Баярхүү. Улс төрийн Товчооны хурлын протокол, Маш нууц, 1965 оны 12 дугаар сарын 1.
<http://www.baabar.mn> 2014.04.04

битүүлэг ноцтой хэрэг явдал гарсан нь Мао Цзедуныг залгамжлагч гэгдэж байсан маршал **Линь Бяо** нарын сууж явсан Англи улсад үйлдвэрлэсэн Trident-IE 256 дугаартай цэргийн нисэх онгоцны сүйрэл юм. 1971 оны 9 дүгээр сарын 12-ны үдэш дээрх онгоц Бээжингийн нисэх онгоцны буудлаас хөөрч, эхлээд зүүн урагш нисэж байгаад эргэж, чанх хойд зүг рүү жолоогоо эргүүлжээ. Онгоц Өвөр Монголыг өнгөрч, БНМАУ-ын хилийг Сүхбаатар аймгийн Асгат сумын нутгаар зөрчин орж ирсэн агаад тун удалгүй Хэнтий аймгийн Бэрхийн уурхайгаас 14 км зайтай, Суваргын хөндийд 02.30 цагт унаж, сүйрсэн байна.

Энэхүү онгоцны сүйрлийн талаар өнөөг хүртэл батттай нотлогдоогүй олон янзын хувилбар байдаг. КГБ-ын мэдээлэл шинжилгээний газрын дарга асан дэслэгч генерал Н.Леонов “Известия” сонинд 1995 онд өгсөн нэгэн ярилцлагадаа: “Хамгийн том оньсого бол Хятадын БХЯ-ны сайд Линь Бяогийн үхэл юм. Түүний сууж явсан онгоц Бээжингээс хөөрч Монгол Улсын нутагт унаж осолдсон. ...Бас нэг таамаглал бол сайдыг ЗХУ руу нисч байхыг мэдсэн түүний бие хамгаалагч онгоцон дотор “гал нээсэн” байж болох юм. Гэвч Маогийн үе залгамжлагч байж болохуйц хүний энэ аялалын гол зорилго ийнхүү хэнд ч мэдэгдэлгүй өнгөрсөн юм” гэжээ. Гэтэл өөр нэг баримтад өгүүлэхдээ: “ХКН-ын ТХ-ны орлогч дарга, БХЯ-ны сайд асан Линь Бяо, түүний гэргий Ей Цюнь нар уг онгоцонд сууж яваад амь үрэгдсэнийг тэдний цогцост хийсэн шинжилгээгээр нотолсон байдаг. Маршал Линь Бяо, Мао Цзедуны эсрэг хуйвалдаан зохиож тэр нь бүтэлгүй болсон учир ЗХУ-д зугатан очихоор тийнхүү нисч явсныг Зөвлөлтийн тал хүлээж авбал Зөвлөлт-Хятадын харилцаанд тааж мэдэшгүй уршиг тарьж мэдэхээр байсан учир түүний сууж явсан онгоцыг Монголын нутагт буудан унагаж, өөрсдөө нэр цэвэр гарснаар барахгүй, бас хятадын удирдагчдыг ч түвэг бэрхшээлтэй хэрэг явдал, хэл амнаас аварсан гэж голдуу Өрнөдөд бичсэн байдаг. Энэ бол Trident-IE 256 дугаартай онгоцны сүйрлийг тайлбарласан нэг хувилбар. Нөгөө талаас зөвлөлт, монголын тал сүйрлийг нотлохдоо онгоц гагцхүү нисэгчийн алдаанаас болж унасан, өөр хөндлөнгийн юу ч нөлөөлөөгүй гэж үзсэн байдаг ажээ. Хятадын албаны хүмүүс хожим монголчууд болон бусад улсын албаны хүмүүст хэлэхдээ онгоцыг Монголд буудаж унагасан гэсэн тэмдэглэл ч бий ажээ.

Trident-IE 256 дугаартай онгоц ЗХУ-ын хил нэвтрэхийн өмнө Чита мужийн Өвөр Байгалийн цэргийн тойргоос онгоцыг хүлээж авах боломжгүй гэсэн шийдийг аваад буцаж эргэж урьд зүг рүү нисч явахдаа Өндөрхааны орчим Суваргын хөндийд осолдсон тухай ЗХУ-ын Гадаад яамны орлогч сайд Михайл Капица МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны гишүүн, ТХ-ны нарийн бичгийн дарга Д.Моломжамцтай Москвагаас хамт нисч явахдаа ярьсан байна.

Тухайн үед Монголын нутагт Хятадын онгоц сүйрч, тэр тухай сонинд товч мэдээ нийтлэхээр ГЯЯ Улаанбаатарт суугаа БНХАУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Сюй Вэнь Ий-д урьдчилан мэдэгдэхэд тэрбээр талархаж, мэдээ гаргах нь Монголын Засгийн газрын хэрэг, гагцхүү мэдээний агуулга нь хоёр орны харилцааг хэвийн болгох үзэл санаанд харшлахгүй байгаасай гэж хүсч байна гэсэн

нь тэр үед анхаарууштай үг байсан юм” гэж ахмад дипломатч Д.Ёндон дурсжээ. Ийнхүү БНМАУ-д хятадын нисэх онгоц сүйрсэн тухай товч мэдээ “Үнэн” сонинд 1971 оны 9 дүгээр сарын 30-нд нийтлэгдэж, БНХАУ байгуулагдсаны ойн өмнөх өдөр хэвлэл, мэдээллийн агентлагууд дэлхий даяар шуугиан тараасан нь олон жил үргэлжилсэн дуулиант хэргийн маргааны эхлэл болжээ.

1973 оны 8 дугаар сард хуралдсан ХКН-ын X Их хурал дээр Мао Цзедун “Намын эсрэг Линь Бяогийн бүлэг”, “Хувьсгалын эсрэг хуйвалдаан”, түүнийг бут цохисон тухай баримтыг хэрэг явдал өнгөрөөд 2 жил болсны дараа ил гаргаж тавьсан юм. Энэ мэдээллээр бол 1970 оны 8 дугаар сард хуралдсан ХКН-ын ТХ-ны 9 дэх удаагийн Чуулганы II Бүгд хурал дээр Линь Бяо “төрийн эргэлт” хийхийг оролдсон, мөн 1971 оны 9 дүгээр сарын 8-нд зэвсэгт үймээн зохион байгуулж Мао Цзедуны амь насанд халдан, өөрийн Төв Хороо буй болгохыг хүсч, хуйвалдаан бүтэлгүй болсны дараа 1971 оны 9 дүгээр сарын 13-нд ЗСБНХУ руу нисч яваад, түүний сууж явсан онгоц БНМАУ-ын нутаг Өндөрхаан орчим унаж сүйрсэн гэжээ. 1973 оны 8 дугаар сарын 24-нд ХКН-ын X Их хурал дээр тавьсан илтгэлдээ Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энълай дээрх баримтыг ч тэмдэглэсэн байна.

1970-аад онд ЗХУ тэргүүтэй социалист хамтын нөхөрлөлийн орнууд БНХАУ-ыг НАТО-гийн 16 дахь гишүүн болов хэмээн сүр дулиантай сурталчилж байв. Энэ нь БНХАУ-ыг социалист системээс улам бүр хөндийрүүлэх болж, энэ нь харилцаагаа сайжруулах хэрэгт том саад болж байсан юм.

Ингээд 1976 оны 1 дүгээр сард Варшавт зохион байгуулагдсан социалист хамтын нөхөрлөлийн орнуудын коммунист, ажилчны намуудын үзэл суртлын асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөнөөр БНХАУ-ыг муучлан бичихээ зогсоохоор шийдвэрлэсэн байна.

Монгол, Хятадын харилцаа

Монгол-Хятадын харилцааг хэвийн болгох асуудал Зөвлөлт-Хятадын харилцаанаас шууд шалтгаалж байсан юм. Зөвлөлтийн удирдагч М.С. Горбачев 1986 оны 7 дугаар сард *Владивостокт* хэлсэн үгэндээ, Японтой сайн хөршийн харилцаа тогтоох, Солонгосын хойгийн асуудлыг энхтайван замаар зохицуулах, Ази-Номхон далайн орнуудыг оролцуулан *Хельсинк маягийн чуулга уулзалт хийх санал дэвшүүлсэнээс* гадна «Түүх Зөвлөлт, Хятадын ард түмэнд онц хариуцлагатай үүрэг ногдуулж байна. Хоёр том улсаас олон улсын хөгжлийн олон зүйл шалтгаална. Манай харилцаа сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц сайжирлаа. ЗХУ Хятадтай сайн хөршийн харилцааны байдал бий болгох нэмэлт арга хэмжээний тухай асуудлыг ямар ч цагт, ямар ч түвшинд хамгийн буурьтай хэлэлцэхэд бэлэн байгааг нотлохыг хүсч байна. Биднийг зааглаж байгаа (холбож байгаа гэж хэлмээр байна) хил ойрын ирээдүйд энхтайван, найрамдлын зурвас болно гэж найдаж байна» гэсэн бол, 1987 оны 7 дугаар сард Индонезийн *“Мердека”* сонинд өгсөн ярилцлагадаа дээрхийг дахин нотолж, 1988 оны 9 дүгээр сард *Красноярскт* хэлсэн үг түвэгтэй байсан хэдий ч Алс Дорнодын олон улсын харилцааны орчин, геополитикийг шинэ сэтгэлгээний

үүднээс шинээр авч үзэх боломж олгосон юм. Тэрбээр хэлсэн үгэндээ Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд юуны өмнө цэргийн сөрөг төвлөрлийг багасгах, итгэлцлийг бэхжүүлэх тухай Хятад, Япон, БНАСАУ, болон анх удаа нэр заан Өмнөд Солонгосыг оролцуулан олон этгээдийн хэлэлцээ хийх санал дэвшүүлэв. М.С.Горбачёв 1988 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 43 дугаар чуулганы индрээс дахин шинэ санаачилга дэвшүүлсэн нь зэвсэгт хүчнээ үлэмж хорогдуулж, Монголоос цэргээ гаргана гэдгээ анх удаа зарлав. Тэрбээр мөн **Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ: Манай орны болон дэлхий дахинд** бүтээлдээ Хятадын «дөрвөн шинэчлэл»-ийн үйл явцаар нэн сонирхолтой, олон талаар үр бүтээлтэй үзэл санааг хэрэгжүүлж буй БНХАУ-тай тогтоосон харилцааны чухлыг тэмдэглэсэн нь Бээжингийн удирдагчдын анхаарлыг зүй ёсоор татсан байна.

1980-аад оны туршид олон үе шаттай явагдсан Зөвлөлт, Хятадын улс төрийн зөвлөлдөх уулзалтын үеэр харилцааг сайжруулахад тээг болж буй «гурван харш саад»-ыг арилгах болзолыг Хятадын талаас байнга тавьж байсан нь “ямар ч тохиолдолд аливаа улсын батлан хамгаалах хүчин гагцхүү өөрийн улсын хилийн дотор байрлах ёстой” гэдэгт үндэслэж байв. «Гурван харш саад»-ыг арилгах гэдэг нь нэгд. Монголоос зөвлөлтийн цэргийг гаргах, хоёрт, Кампучиас Вьетнамын цэргийг гаргуулах, гуравт, Афганистанаас зөвлөлтийн цэргийг гаргах, эдгээр асуудлыг шийдвэрлэсэн тухайд л харилцааг хэвийн болгох боломжтойд оршиж байв. Тиймээс Бээжингийн удирдагчид «гурван харш саад» гэдэг нь Хятадыг гурван талаас нь бүслэсэн байдлыг хэлж буй юм гэж Зөвлөлтийн талд тов тодорхой ойлгуулж байжээ.

1963 онд АНУ Хятадын өсөн нэмэгдэж болох аюулыг дарахын тулд ЗХУ-д хандаж, хэрэв АНУ цөмийн зэвсэг хэрэглэн Хятадын эсрэг “урьдчилан сэргийлэх” цохилт хийвэл ЗХУ ямар байр суурьтай байхыг тандаж байжээ. Мэдээж ЗХУ түүнийг дэмжээгүй. Монголтой хиллэдэг Хятадын цөмийн зэвсгийн туршилтын болон цөмийн бусад барилга байгууламжийн эсрэг АНУ цөмийн зэвсэг хэрэглэсэн бол Монгол Улс хир хохирох байсан нь тодорхой юм. 1969 онд Зөвлөлт-Хятадын харилцаа хурцдаж, хилийн дагуу удаа дараа зэвсэгт мөргөлдөөн гарч байх үеэр ЗХУ-ын удирдлага тухайн үед 50 орчим цөмийн зэвсэгтэй болж байсан Хятадын цөмийн зэвсэг, байгууламжуудын эсрэг цөмийн урьдчилсан цохилт хийх замаар устгах боломжийг судалж, энэ талаар Варшавын Гэрээний орнуудын холбоотнууддаа аминчлан мэдэгдэхийн дээр АНУ-ын байр суурийг тандаж байсан байдаг.

Өөрийн аюулгүй байдлыг хангах нь бусдын аюулгүй байдлыг ямагт хөндсөөр иржээ. Зэвсэглэлээр хөөцөлдсний гол уг сурвалж үүнд л оршиж байв. БНХАУ оршин тогтнож байсан түүхийнхээ туршид аюулгүй байдлаа дангаараа хангаж байсан гэж үздэг. Мөн Хятад нь найрсаг хөршүүдээр хүрээлүүлж байгаагүй гэж үзэж байсан ажээ. Аль ч улс, гүрнүүдийн хооронд цэрэг-аюулгүй байдлын салбарт харилцан итгэлцлийг бэхжүүлэх нь хичнээн чухал гэдэг нь эндээс тодорхой байгаа юм.

1989 онд Афганистаны асуудлаар Женевийн хэлэлцээр байгуулагдаж, тус орноос зөвлөлтийн цэрэг гарав. 1989 оны 9 дүгээр сарын эцэс гэхэд Кампучиас Вьетнамын “сайн дурынхан”-ыг бүрэн гаргах тухай Вьетнам, Кампучи, Лаосын 1989 оны 4 дүгээр сарын 5-ны Парисын Энхтайвны бага хурлаас гаргасан хамтарсан Тунхаглал улс төрийн томоохон үйл явдал болов. Нийтдээ Вьетнамын 24 мянган цэрэг, офицер, зэвсэг, хүнд техникүүд гарав.

«Хил дээрх цэргийн тоог цөөлөх тухай Зөвлөлт-Хятадын хэлэлцээр»-ийг 1989 оны 2 дугаар сарын 4-нд Бээжин хотноо байгуулсан юм. Дурьдсан хэлэлцээрийн дагуу хоёр улс өөрийн хилийн дагуу төвлөрүүлсэн цэргийн тоог цөөрүүлэх, Афганистан болон Монголоос Зөвлөлтийн цэргийг гаргахаар тохиролцсон байна.

Зөвлөлтийн удирдагчдаас гучин жилийн дараа М.С.Горбачев 1989 оны 5 дугаар сард Хятадад албан ёсны айлчлал хийсэн нь дэлхий дахины анхаарлыг онцгой татсан юм. М.С.Горбачев Хятадын удирдагч Дэн Сяопингтэй уулзахдаа Монгол дахь Зөвлөлтийн цэргийн 75 хувийг ойрын үед эх оронд нь буцаах бөгөөд үлдсэн 25 хувийг гаргах боломж, хугацааны тухай асуудлыг БНМАУ-тай хэлэлцэх болно гэжээ. Мөн Зөвлөлт-Хятадын харилцааны сайжрал нь гуравдагч этгээдэд (Монгол Д.У) хохирол учруулахгүй гэж мэдэгджээ.

Зөвлөлтийн удирдагч М.С.Горбачев БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэнтэй уулзах үеэр Хятадын тал Зөвлөлт-Хятадын харилцаа сэргэж, хэвийн болсныг өндөр үнэлэхийн хамт, хоёр орны харилцаа цаашдаа 1950-иад оны үеийнх шиг холбоотны харилцаанд хэзээ ч тулгуурлахгүй гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.¹²

1982 оны 10 дугаар сараас Зөвлөлт, Хятадын улс төрийн зөвлөлдөх уулзалтын Хятадын талын тэргүүн, ЗХУ-д сургууль төгссөн, “зөвлөлтийн талаарх гол мэргэжилтэн” Цянь Цичэнь 1988 онд ГЯЯ-ны сайд У Сюэцянь-ийн оронд шинээр томилогдсон нь санамсаргүй зүйл биш байв. Тэрбээр гадаад дахь айлчлалаа ЗХУ-аас эхэлж, Москвад хийсэн яриа хэлэлцээний үеэр «гурван харш саад»-аа татаж авснаа нотолж, мөн Монголын тусгаар тогтнолын асуудлаар Хятадын анхны албан ёсны байр суурийг илэрхийлжээ.

ЗХУ Монголоос бүх цэргээ татахын хамт Хятад, Зөвлөлтийн хилийн дагуух цэргийг хамгийн доод түвшинд хүртэл хорогдуулах, хорогдуулсан цэргээ бусад оронд шилжүүлэн байрлуулахгүй байхыг хүсч байгаагаа Цянь Цичэнь Зөвлөлтийн дипломат албаны тэргүүн Э.Шевардназед мэдэгдээд БНХАУ Монгол Улстай найрамдалтай, сайн хөрш байхыг эрмэлзэж байгаа бөгөөд БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх үндсэн дээр тус улстай харилцах бодолтой байна гэдгээ нотолсон нь Монголын талын анхаарлыг зүй ёсоор татаж, чухамдаа Монгол, Хятадын ГЯЯ-ны сайд нар

¹² Визит Генерального секретаря ЦК КПСС, Председателя Президиума Верховного Совета СССР М.С. Горбачева в Китайскую Народную Республику 15-18 Мая 1989 года. Документы и материалы. Изд. Политической литературы. М.: 1989, стр. 17-18

харилцан айлчлах дипломатын урьдчилсан нөхцөл болсон байна. Цянь Цичэнь 1988 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейи чуулганы үеэр БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнгэй анх удаа уулзаж, түүнийг Хятадад айлчлахыг урьж, дараахан нь ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д. Ёндон айлчлалыг нарийвчлан тохиролцохоор Бээжинд очиж Цянь Цичэньгэй уулзжээ.

Тийнхүү Зөвлөлтийн цэрэг гарч эхлэхтэй давхцан сайд Ц.Гомбосүрэн 1989 оны хавар Хятадыг зорив. Тэрбээр айлчлалын өмнөхөн ТАСС-ын улс төрийн тоймчид ярилцлага өгчээ. “Ер нь дэлхийн аль ч нутагт, хэний ч цэрэг үндэснийхээ хил хязгаарын гадна байх ёсгүй гэдгийг та бид ойлгож байна. Гэхдээ энэ бол улс төрийн зохих зориг хүсэл, багагүй хүчин чармайлт гаргаж байж биелэх зүйл юм. Харин бидний ярьж байгаа тодорхой асуудлын тухайд бол энэ асуудлыг буй болгосон улс төр, түүхийн болон бусад тодорхой хүчин зүйлийг харгалзан авч үзэх ёстой нь мэдээж. Зөвлөлтийн цэрэг БНМАУ-д өөрийн дураар биш, харин манай хил хязгаарын аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн Монголын Засгийн газрын хүсэлтээр манай нутагт орж ирсэн гэдгийг Бээжинд сайн мэдэж байгааг үүнтэй холбогдуулан тэмдэглэе. Ингэхлээр Монголын Засгийн газар л Зөвлөлтийн цэргийг манай орны нутаг дэвсгэрээс гаргах эсэх тухай асуудлыг шийдвэрлэж, энэ талаар Зөвлөлтийн талд санал тавих эрхтэй. Тийм учраас энэ бол БНМАУ, ЗСБНХУ-ын мэдлийн асуудал. Монгол-Хятадын улс төрийн тэнгэрт нэг ч үүлгүй байна гэж батлан хэлэхэд арай эрт боловч БНМАУ, БНХАУ-ын харилцаа хэвийн болох үйл явц ямар нэгэн саад доголдолгүй жигд явж байна” гэж хэлсэн нь шийдлийн үгийг Москва, Бээжинд биш, Улаанбаатарт хэлнэ гэсэн санаа байв. Гэвч эцсийн шийдлийг хоёр хөрш хоорондоо тохиролцон гаргасан билээ. Ц.Гомбосүрэн сайдын айлчлалын үеэр “БНМАУ, БНХАУ-ын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “БНМАУ-ын Ерөнхий консулын газрыг БНХАУ-ын Хөх хотод сэргээн байгуулах тухай хэлэлцээр”, “Иргэд харилцан зорчих журмын тухай хэлэлцээр”-т гарын үсэг зурав. Монголын сайдыг БНХАУ-ын дарга Ян Шанкунь хүлээн авч уулзах үеэр АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнхийг Хятадад айлчлахыг урьсан байна.

ЗХУ-ын ГЯЯ-ны Азийн асуудал эрхэлсэн орлогч сайд Игорь А.Рогачёв 1989 оны 3 дугаар сард Улаанбаатарт ажлын айлчлал хийх үеэрээ нэгэн шинэ баримт дэлгэсэн нь Зөвлөлтийн цэргийг гаргах тухай яриа хэлэлцээ ЗХУ-д өөрчлөн байгуулалт эхэлж байх үед 1986 онд Монгол-Зөвлөлтийн хооронд нууц байдалд явагджээ. Э.А.Шеварднадзе 1986 оны 1 дүгээр сард ЗХУ-ын ГЯЯ-ны сайдын хувиар БНМАУ-д анх удаа бие даасан айлчлалаа хийж, улс төрийн шинэ сэтгэлгээ, өөрчлөн байгуулалтын талаар санал солилцож, энэ үеэр БНМАУ, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтооход саад болж байсан хойд хөршийн «moratorium» буюу “түр азнах” хоригийг нэг мөр шийдвэрлэсэн юм. Түүнчлэн маш чухал нууц асуудал болох БНМАУ-аас Зөвлөлтийн цэргийг гаргах тухай асуудал хөндөгджээ. Энэ тохиролцооны дагуу 1986 оны намар цэргийн эхний хэсэг Хятадын Синьцзян-

Уйгуртай хиллэж байсан Говь-Алтай, Ховд аймгаас эх орондоо буцсан байна. Улмаар 1989 оны 5 дугаар сараас Монголоос Өвөрбайгалийн 39 дүгээр армийн бүрэлдэхүүнд багтаж байсан цэргийн бүлэглэл (военной группировки) болох танкийн 2, мотобуудлагын 3 дивиз (1861 танк, 2531 байлдааны хуягт машин), нисэх хүчний 1 дивиз (190 бөмбөгдөгч болон сөнөөгч, 130 нисдэг тэрэг), 1461 артиллерийн их буу, радар-локаторын цогцолбор, 120 мянган цэргээс 50 мянга 320 хүнийг гаргасан байна. Нийтдээ 50 гаруй цэргийн хотхон, бааз байрлаж байжээ. 1979 оны 2 дугаар сард БНХАУ БНСВУ-д түрэмгийлсний дараа тухайн жилд ЗХУ-аас 1 тэрбум шилжих рублийн буцалтгүй тусламжийн хүрээнд сүүлийн үеийн танк, их буу бусад зэвсэг хэрэгсэл авсан байна.

Түүнчлэн Богд хан уулын урд хормойд байрлаж байсан Радио-соронзон долгион барих, пуужингийн довтолгооноос эсэргүүцэн хамгаалах тагнуулын маш нууц томоохон хоёр цогцолбор станцыг нууцалж, удтал хэлэлцсэний эцэст татан буулгасан байна. Эдгээр станцууд бүс нутгийн хэмжээний стратегийн тагнуулын ажиллагаа явуулж байсан байна. Цэрэг, зэвсэг техник гаргах ажиллагаа хоёр үе шаттайгаар явагдаж 1992 оны 12 дугаар сард бүрэн шувтарчээ. Үүнтэй нэгэн зэрэг Монголд ажиллаж байсан зөвлөлтийн 20 гаруй мянган мэргэжилтэн, ажилчид ч мөн нутаг буцжээ.

1980-аад онд ЗХУ-ын ЭСЯ-нд ажиллаж байсан дипломатч, монгол судлаач Ю.Н.Кручкин нэгэн баримт дэлгэснийг энд эш татмаар байгаа юм. Тэрбээр «ЗХУ тухайн үед жилд Монголын 4.5 сая малыг толгойг нь 3 рублээр үнэлж авч байсан байдаг. Монгол Улс зөвлөлтийн томоохон мэргэжилтнүүдийг ердөө сарын 3 ам. доллараар ажиллуулж байсан байдаг. Мэдээж хэрэг мэргэжилтнүүд маш өндөр цалин авч байжээ. Гэхдээ тэр цалингийн 97 хувийг ЗХУ төлж байсан юм. ХХ зуунд ийм хямдхан гадаадын мэргэжилтэн ажиллуулж байсан өөр улс байхгүй. *Хоёрдугаарт* тэр мэргэжилтнүүд дандаа нэрд гарсан алдартай хүмүүс байсан байдаг» гэжээ.

ЗХУ-ын «зөвлөмжөөр» БНМАУ-ын Засгийн газар ЗХУ-д хүсэлт тавьж, тийнхүү Зөвлөлтийн хориглолтын бус давшилтын зориулалттай цэргийн асар том бүлэглэл Монголд «түр» байрлаж байсан билээ. *Монгол Улс Зөвлөлтийн цэргийн асар том давшилтын хүчийг өөрийн нутагт байрлуулж байсан атлаа Японы Окинава, Өмнөд Солонгост байрлаж байсан АНУ-ын цэргийн баазыг тэдгээр улсуудаас гаргахыг шаардаж байсан юм.* Монголын удирдагч Ж.Батмөнх 1985 оны 6 дугаар сард Монгол-Болгарын найрамдлын цуглаан дээр хэлсэн үгэндээ: «АНУ, Ази тивд байрлуулсан цэргийн хүчээ улам зузаатгаж, энэ тивийн өргөн уудам газар нутгийг цөмийн дайны талбар болгохоор санаархаж байна. АНУ Японы милитаризмыг сэргээх явдлыг элдвээр өөгшүүлж, Алс Дорнодод цэргийн томоохон эвслийн гол цөм болгох зорилгоор Япон, Өмнөд Солонгостой цэрэг-улс төрийн холбоо байгуулж байна»¹³ гэжээ. Тухайн үед БНМАУ-ын удирдлага өөрийн нутаг дэвсгэрт 120 мянган цэргийн бие бүрэлдэхүүнтэй, танкийн 3 дивиз, нисэх

¹³ Батмөнх Ж. Илтгэл, хэлсэн үг. УБ.: 1986, 245 дахь тал

хүчний 1 дивиз бүхий хориглолтын бус, давшилтын зориулалттай Зөвлөлтийн цэргийн асар том бүлэглэлийг «өөрийн хүсэлтээр түр» байрлуулж байсан атлаа Япон, Өмнөд Солонгост байрлаж байсан АНУ-ын цэргийн баазыг тэндээс гаргахыг шаргуй шаардаж байв. Хятадын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь 1989 оны 8, 9 дүгээр сарын заагт Монгол Улсад хариу айлчлал хийж, **хоёр орны харилцаа бүрэн хэвийн болсныг нотлов**. Айлчлалын үеэр БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрхзүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээнд гарын үсэг зуржээ.

НОМ ЗҮЙ

1. Malcolm Byrne, Vladislav Zubok. The Intervention in Afghanistan and the Fall of Détente. A Chronology. The National Security Archive, THE CARTER-BREZHNEV PROJECT.
2. “The Rise and Fall of Détente”, Professor Branislav L. Slantchev, Department of Political Science, University of California – San Diego.: 2014
3. “The Crisis of Détente in Europe”. N.Y.: 2008
4. Bowkerl, Mike & Williams, Phil. Superpower Détente: *A Reappraisal*. SAGE Publications.: 1988
5. Suri, Jeremi. Power and Protest: Global Revolution and the Rise of Détente. Harvard University Press.: 2003
6. Sarotte, M. E. Dealing with the Devil: East Germany, Détente and Ostpolitik, 1969–1973. University of North Carolina Press.: 2001
7. Kevorkov, Vyacheslav (2010). Виктор Луи : человек с легендой (Victor Louis : Man with the Legend). Семь Дней (Sem’ Dnei). ISBN 978-5-88149-449-0.
8. Кулик Б.Т, “Советско-Китайский раскол , причины и последствия”. М., 2000 с.212-213
9. ГХТА. Ярианы тэмдэглэл, Хувийн архивийн баримт ХН-2, 6-8 дахь тал
10. Д.Ёндон. Том хориг. УБ.: 2007
11. Ж.Бор. Д.Уламбаяр. Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг. Дэд боть. К-Р, УБ.: 2014
12. Горбачев М.С. Перестройка и новые мышление для нашей страны и для всего мира. Изд. Политической литературы. М.: 1988
13. Горбачев М.С. Избранные речи и статьи. Изд. Политической литературы. М.: 1989
14. Далай Ч. Отношения между МНР и КНР (1949-1984 гг.) Автореф. докт. дисс.
12. Инст. Истории АН МНР, УБ., 1986
15. Монгол Улс. Гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. IX боть. (1990-2001). УБ., 2001
16. Китайская Народная Республика: 1984 политика, экономика, культура. М.: 1987
17. Китайская Народная Республика: 1986 политика, экономика, культура. М.: 1988
18. Китайская Народная Республика: 1987 политика, экономика, культура. М.: 1989
19. Китайская Народная Республика: 1988 политика, экономика, культура. М.: 1990
20. Китайская Народная Республика: политика, экономика, культура в 1989-1990 годах. М.: 1992
21. Международный Ежегодник: Политика и экономика-1988. М.: 1988
22. Международный Ежегодник: Политика и экономика-1989. М.: 1989
23. Энциклопедия Нового Китая. (перевод на русский язык с сокр.) Изд. “Прогресс”, М.: 1989
24. Проблемы Дальнего востока. Жур: ИДВ АН СССР. № 1988-1992
25. Мировая экономика и международные отношения. Жур: ИМЭМО АН СССР. № 1988-1991
26. Визит Генерального секретаря ЦК КПСС, Председателя Президиума Верховного Совета СССР М.С. Горбачева в Китайскую Народную Республику 15-18 Мая 1989 года. Документы и материалы. Изд. Политической литературы. М.: 1989